

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 02 сарын 25

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, хүрсэн түвшинг тусгагдсан зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, удаашралтай хэрэгжиж байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу 2021 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1-д заасан арга зүйгээр төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээг хагас бүтэн жилээр хийж, төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүний хэрэгжилт үр дүнгийн талаар Тамгын газрын дарга болоод хамт олныг үнэн зөв мэдээллээр хангах үндсэн чиг үүргийн дагуу ажилласан.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээллийг ирүүлсэн тайлангаас гадна холбогдох хэлтэс, алба, нэгжээс нэмэлт тодруулга авах, мэдээлэлтэй тулган үзэх замаар 40 зорилт, 145 арга хэмжээний дундаж үнэлгээгээр тооцлоо.

## ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Дундговь аймгийн засаг даргын Тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 2 хэсгийн 40 зорилтын хүрээнд 145 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 40 зорилт, 145 арга хэмжээний дундаж 95,7 хувьтай байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлгээний аргачлалаар ангилж харуулбал:

	Үнэлгээ
100%	132
90%	2
70%	4
50%	2
30%	1
0%	3
ДУНДАЖ	95.76%

## 2022 ОНД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд оюутнуудын сургалтын төлбөрийг хариуцан, орон нутагтаа ажиллах гэрээ хийж, хүний нөөцөө тогтвор суурьшилтай ажиллахад анхаарч байна.






## ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ

### СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

Байгууллага, аж ахуй нэгж, холбоо,  
клубийн

**37 679** иргэнийг хамруулан, мэдээлэл  
сургалт сурталчилгааг нийт хүн амын  
**82.3** хувьд хүргэлээ.



**2022** онд  
**5** удаагийн нөлөөллийн  
арга хэмжээ зохион  
байгууллаа.



## БОЛОВСРОЛ-ХАМТЫН АЖИЛЛАГАА

ЭЕШ оноогоор улсад тэргүүлдэг ерөнхий боловсролын “Оюунлаг” сургуультай санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна.


Монгол улсын боловсролын их сургууль, Глобал удирдагч их сургуулиудтай хамтран 160 гаруй албан хаагчдыг магистрийн хөтөлбөрт хамруулж байна.



Жуулчдаг үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой 4 эвент арга хэмжээг зохион байгуулж 16650 гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон.



**БНХАУ, Солонгос, Япон**  
Улсын муж хотууд, **Канад,**  
**АНУ**-ын хөрөнгө  
оруулалттай олон улсын  
байгууллагууд, Элчин  
сайдын яамдтай хамтран **15**  
**төсөл хөтөлбөр** хэрэгжүүлэн  
орон нутгийн хэмжээнд  
гадаадын хөрөнгө оруулалт  
**1,972,9 сая** төгрөгт хүрээд  
байна.



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Дундговвио ногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд **122,884 мод, сөөг** тарьж ургууллаа. “Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх” хөтөлбөрийн хүрээнд **8 га, ойн зурвас** байгуулах ажлын хүрээнд **5 га нийт 13 га газарт ойн зурвас** байгуулж нийт ногоон **байгууламжийн хэмжээ 382.4 га** болсон.



Олон нийтийн хандив дэмжлэгийн үндсэн дээр **1,5 тэрбум** төгрөгийн өртөг бүхий олон талт сургалт, хөтөлбөр, сэтгэл зүй, нийгмийн ажлын үйлчилгээ, номын сан, кофе шоп хосолсон **“ИД ШИДИЙН ОРОН”** төвийг хөдөө орон нутгаас анх удаа бий болж хүүхэд багачуудын маань хөгжих томоохон бүтээн байгуулалт боллоо.



Азийн хөгжлийн банкны хөрөнгө **9,1 тэр бум** төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвд хоногт **3000 м3** хүчин чадалтай **биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж**, гэр хорооллын **5,57 км** гадна бохир усны сүлжээний ажлыг хүлээн авлаа.




## “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО ДУНДГОВЬ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

“Тогтвортой хөгжил-Шинэ сэргэлтийн бодлого Дундговь” хэлэлцүүлэг Эдийн засаг, хөгжлийн яамны дэд сайд асан, Эрдэнэс Монгол ТӨХК-ийн захирал С.Наранцогт, тус яамны БНАУБГазрын дарга Д.Эрдэнэбаяр, УИХ-ын гишүүн асан, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор Н.Тогтох, “Эрчим хүчний төлөө Монголын нийгэмлэг” ТББ-н захирал Д.Пүрэвбаяр нар оролцлоо.

Тус хэлэлцүүлэгт оролцогчид “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг орон нутаг эрчимжүүлэх нь, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын төсөл, “Палеонтологийн нөөцөд тулгуурлан амралт судалгаа, аяллын цогцолборыг Дундговь аймагт байгуулах боломж”, “Хунгарласан элс, хаягдал цаас, агаарын бохирдлыг бууруулах” төслүүдийн танилцуулгыг, аймгийн ЗДТГ-ын дарга Л.Доржбат “Гипс хавтан болон шохойн блокны үйлдвэр байгуулах”, “Малчдын хөгжлийн парк” байгуулах зэрэг төслүүдийг тус тус танилцуулж цаашдын төлөвлөлт, үйл ажиллагааны талаар хэлэлцлээ.

Мөн “Аймаг орон нутагт шилжин ирж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих дэд ажлын хэсэг”-ийн 2023-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г танилцуулж тус арга хэмжээнд оролцогч төрийн албан хаагчид, иргэдээс нэгдсэн төлөвлөгөөнд тусгах санал хүсэлтийг авсан юм.





### “ДУНДГОВЬД ҮЙЛДВЭРЛЭВ” БОРЛУУЛАЛТЫН ЦЭГ НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ

Зах зээл бэлчээрийн удирдлага төсөл, орон нутгийн хөгжлийн сангийн 400 гаруй сая төгрөгийн хөрөнгөөр тус төвийг барьж ашиглалтад хүлээлгэн өгч „Дундговь аймгийн баялаг бүтээгчид болох жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, идэвхжүүлэх, сурталчлах, тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг шимтгэлгүйгээр борлуулах боломжийг олгож , жуулчдад зориулсан онцлог бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулах, өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна.







**Хэрэгжилт нь 0-30 хувьтай буюу үр дүнгүй хэрэгжсэн 4 арга хэмжээ байна.**


Арга хэмжээ	Хэрэгжээгүй шалтгаан	Хувь
Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах	Зэвсэгт хүчний жанжин штабаас сургалтын зардлыг Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу тус аймагт явагдах сургалтыг хасаж шийдвэрлэсэн.	0
Аймгийн 2022 оны цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулах	Аймгийн 18-60 насны цэргийн үүрэгтэн 2022 оны тоо бүртгэлд хамрагдалтыг 90 хувьд хүргэхээс 82,7%-тай бүртгэлд хамрагдлаа.	0
Төрийн архивын орон тоог нэмэгдүүлэх	Төрийн архивд одоогийн байдлаар төсөв санхүүгийн боломжгүйгээс орон тоог нэмэгдүүлэх ажил хийгдээгүй болно.	0
Орон нутгийн болон улсын төсвийн зарлага, санхүүжилтийг гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийн үр ашгийг дээшлүүлэх.	Нийт аудитлагдсан тайланд зөрчилгүй дүгнэлттэй байгууллагын эзлэх хувь 90 хувь байхаас 86,1 хувьтай байна.	22

**ҮР ДҮНГҮЙ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛТГААНЫГ ТОДРУУЛЖ СУДАЛЖ ҮЗЛЭЭ**



## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2022 оны биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1- т заасан үнэлгээний аргачлалын дагуу 40 зорилт, 145 арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу суурь түвшин, зорилтот түвшин, хүрсэн түвшинг харьцуулан хяналт шинжилгээ, үнэлгээг хийж байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 95,7 хувьтай гэж дүгнэв.



### Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хамт /хүснэгтээр/

№	Хамрах хүрээ	Эх үүсвэр	Зарцуулалт /сая/	Дүн
1	Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд	УТХО	3451,2	8172,9
		ОНТ	1501,3	
		Хувийн хэвшил, хандив	1979,7	
		Гадаадын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр	1240,7	
2	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд	УТХО	30486,1	47029,7
		ОНТ	8887,6	
		Хувийн хэвшил, хандив	12,7	
		Гадаадын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр	7643,3	
Нийт дүн				55202,6

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 55 тэрбум 202.6 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс: Улсын төсвийн хөрөнгөөр 33937.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 10 тэрбум 388,9 сая төгрөг, хандив тусламжаар 1992,4.6 сая төгрөг, гадаадын хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 8884,0 сая төгрөг зарцуулж хэрэгжүүлсэн байна.

### **ТАВ. ЗӨВЛӨМЖ**

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдэд:**

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд агентлагийн ажил тусгахгүй байх /Бодлогын хэлтсийн хувьд хийх ажлаа оновтой тодорхойлж төлөвлөх/
2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд саналаа ирүүлэхдээ бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх
3. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг судлан ажилдаа мөрдлөг болгох
4. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг ойлгомжтой байдлаар, тоо баримттайгаар үр дүнд хүрсэн эсэхийг тодорхой байдлаар баримтжуулан тайлагнах
5. Зарцуулсан төсвийн хэрэгжилтийг тайлагнахдаа сая.төгрөгөөр тоо баримтыг эмх цэгцтэй, эх үүсвэрийг тодорхой, тус тусд нь ялгаж тооцож тайлагнах
6. Арга хэмжээний шалгуурыг хүрэх түвшиндээ хүрсэн эсэхийг тайланд тоон мэдээллээр тусгаж тайлагнах
7. ТЗУХэлтэс төлөвлөлт, тайлагналтыг хэлтсүүдээс авч нэгтгэхдээ шаардлага хангасан төлөвлөлт, чанартай тайланг авч байх
8. ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь аймаг дүгнүүлэх 1 үзүүлэлт болсон тул төлөвлөлт, тайлагналтандаа анхаарч, хэлтсийн дарга нар хянаж байх
9. Удаашралтай, үр дүнгүй хэрэгжиж буй арга хэмжээг хяналтандаа авч, удирдлагуудад танилцуулан, цаашид хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, эрчимжүүлж ажиллах

Цаашид төлөвлөлтийг хийхдээ зорилт, арга хэмжээ 2-ын уялдааг сайн хангах, салбарын бодлоготой уялдуулан шалгуур үзүүлэлтийг бодитой зөв томъёолох шаардлагатай байгааг онцолж байна.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**